УХТЭ-ийн ангиографийн тасгийн зүрх судасны хэсэгт хийгдэж буй ажилбарын өнөөгийн байдал

Л.Эрдэнэхүү[1], Д.Жаргал[1], Б.Батболд[2], А.Хандаа[2], Ж.Ишжамц[2], Д.Эрдэнэбат[2]
Н.Сүхбаяр[3], Х.Дашдэмбэрэл[3], Д.Амарзул[3]

[1]Тусгай тасаг, УХТЭ
[2]Ангиографийн оношилгоо эмчилгээний тасаг, УХТЭ
[3]Зүрх судас судлалын тасаг, УХТЭ

Түлхүүр үг:

Зүрхний титэм судасний оношилгоо эмчилгээ
Бөөр болон тархины судасны ангиографийн шинжилгээ
Зүрхний пейсмейкер эмчилгээ

Товч утга: УХТЭ-ийн үндэсний оношилгоо эмчилгээний төв ашиглалтанд орж ангиографийн тасаг бий болсонтой холбоотой зүрхний титэм судасний оношилгоо эмчилгээ, бөөр болон тархины судасны ангиографийн шинжилгээ, зүрхний пейсмейкер эмчилгээ хийгдэх болсон юм. Бид зүрх судас болон тархины судсан дотуурх оношилгоо эмчилгээг үр дүнтэй, хүндрэл эрсдэл багатай, хүртээмжтэй хийж хэвшүүлэхийг зорьсон. Одоогоор титэм судсан дотуурх оношилгоо 68, бөөрний судасны ангиографийн шинжилгээ 6, титэм судсан дотуурх эмчилгээ 15, пейсмейкер эмчилгээ 10, тархины судасны ангиографийн шинжилгээ 4 тохиолдол тус тус хийгдээд байна. Цаашид зүрхний цочмог шигдээс болон титэм судасны архаг бөглөрлийн үед тусламж үйлчилгээ үзүүлж титэм судасны оношилгоо эмчилгээнд зайлшгүй шаардлагатай дэвшилтэт технологи болох FFR болон IVUS багажуудыг эмнэлзүйд нэвтрүүлэх нь эмчилгээ үйлчилгээний чанарт сайнаар нөлөөлнө. Тархины судасны ангиографийн оношилгоог төрөлжүүлж тархины судсан дотуурх эмчилгээг өөрийн эмнэлэгт нэвтрүүлэх шаардлагатай байна

Үндэслэл: Үндэсний эрүүл мэндийн үзүүлэлтээс (2019) харахад Монголчуудын хувьд нас баралтын тэргүүлэх шалтгаан (34.7%) нь зүрх судасны өвчин юм. Жилд дунджаар 5700 гаруй хүн буюу нас барсан 3 хүний нэг нь зүрх судасны тогтолцооны өвчнөөр нас барж байна.


Зүрхний шигдээсийн оношилгоо, эмчилгээнд дэвшилтэт технологи 1997 оноос Монгол улсад нэвтэрч, титэм судсан дотуурхи оношилгоо, эмчилгээг хийх болсон. Манай судлаачид "ТиСДЭ-ний үр дүн 92,9% байж, уг эмчилгээний эрт үеийн хүндрэл 3,2%-д, хожуу үеийн хүндрэл 13,1%-д нь илэрч, 7,1% нь нас барсан" гэж дүгнэжээ.

Сүүлийн 10 жилийн дунджаар зүрхний шигдээс өвчнөөр жилд 2.5 мянган хүн нас барсны 60.0 хувь эрэгтэй, 40.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэхүү өвчнөөр 2019 онд 2667 хүн нас барсан нь сүүлийн 10 жилийн дунджаас 68 буюу 2.7 хувиар, өмнөх оноос 194 буюу 7.3 хувиар буурсан байгаа нь манай оронд титэм судсанд дотуурх оношилгоо эмчилгээ болон зүрхний электрофизиологийн шинжилгээ хөгжиж буйтай холбоотой юм.

Зорилго: Бид зүрх судас болон тархины судсан дотуурх оношилгоо эмчилгээг үр дүнтэй, хүндрэл эрсдэл багатай, хүртээмжтэй хийж хэвшүүлэхийг зорьсон.


Хэрэглэгдэхүүн ба арга аргачлал: УХТЭ-ийн үндэсний оношилгоо эмчилгээний төв ашиглалтанд орж ангиографийн тасаг бий болсонтой холбоотой зүрхний титэм судасний оношилгоо эмчилгээ, бөөр болон тархины судасны ангиографийн шинжилгээ, зүрхний пейсмейкер эмчилгээ хийгдэх болсон юм.

Үр дүн: Одоогоор титэм судсан дотуурх оношилгоо 64, титэм судасны болон бөөрний судасны ангиографийн шинжилгээ 4, титэм судсан дотуурх эмчилгээ 15, пейсмейкер эмчилгээ 10, тархины судасны ангиографийн шинжилгээ 4 тохиолдол тус тус хийгдээд байна.




Зураг 1 Титэм судсан дотуур оношилгоо, эмчилгээ хийлгэсэн өвчтөнүүд

Титэм судсан дотуур оношилгоо, эмчилгээ хийлгэсэн өвчтөнүүд нь 23-90 насныхан байгаа бөгөөд 50-70 насныхан ихэнхи хувийг эзэлсэн бөгөөд эрэгтэйчүүд 63%-ийг эзэлж байна.



Зураг 2 Титэм судасны оношилгоо зүүн титмийн уруудах салаа болон баруун титэм артерийн нарийсал

Титэм судасны оношилгоо хийлгэсэн өвчтөнүүдийн 51% нь судасны ямар нэг нарийсалтай байсан бөгөөд зүүн титмийн уруудах салаа болон баруун титэм артерийн нарийсал 70%-ийг эзэлж байна.



Зураг 3 Титэм судасны нарийслийн зэрэг

Нарийслийн зэргийн хувьд 75%-иас илүү нарийсал болон архаг бөглөрөл 54%-ийг эзэлсэн.

Хэлцэмж ба дүгнэлт: Цаашид тус эмнэлэг нь үйлчлэх хүрээг өргөтгөж аймаг, дүүргийн хүн амд үйлчлэх болсонтой холбоотой ажилбарын тоо болон нэр төрлийг нэмэгдүүлэх нь зүйтэй. Ялангуяа титэм судасны оношилгоо эмчилгээнд зайлшгүй шаардлагатай дэвшилтэт технологи болох FFR болон IVUS багажуудыг нэвтрүүлж зүрхний цочмог шигдээс болон титэм судасны архаг бөглөрлийн үед тусламж үйлчилгээ үзүүлэх, зүрхний хавхлагын гажиг, төрөлхийн цоорхой, гол судасны цулхэн, хуулрал, захын судасны бөглөрөл, нарийслыг судсан дотуур оношлох, эмчлэх их ажил хүлээж байна. Мөн тархины судасны ангиографийн оношилгоог төрөлжүүлж тархины судсан дотуурх эмчилгээг өөрийн эмнэлэгт нэвтрүүлэх шаардлагатай байна.

Current status of procedures performed in the cardiovascular area of department of angiography in Second State Central Hospital

L.Erdenekhuu[1], D.Jargal[1], B.Batbold[2], A.Khandaa[2], J.Ishjamts[2], D.Erdenebat[2], N.Sukhbayar[3], Kh.Dashdemberel[3], D.Amarzul[3]

[1]Special department, Second State Central Hospital
[2]Angiography diagnosis and treatment department, Second State Central Hospital
[3]Cardiovascular Department, Second State Central Hospital

Abstract: With the establishment of National Diagnostic and Treatment Center in Second State Central Hospital and Department of Angiography, a diagnosis and treatment using coronary angiography, renal or cerebrovascular angiography and pacemaker treatment were provided. We aimed to make the cardiovascular and cerebrovascular diagnosis and treatment effective, risk-free, and accessible. Currently, 68 cases of coronary angiography, 6 cases of renal vascular angiography, 15 cases of coronary endovascular treatment, 10 cases of pacemaker treatment and 4 cases of cerebrovascular angiography have been performed. Further, treatment and care for acute myocardial infarction and chronic coronary occlusion, and introduction of FFR and IVUS instruments, which are essential technologies for coronary diagnosis and treatment, will have a positive impact on the quality of our healthcare and medical service. There is a need to diversify cerebrovascular angiography and introduce cerebral intravascular treatment in our hospital.

Keywords: Cardiovascular and cerebrovascular angiography, diagnosis and treatment